

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Автотээврийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/05/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2023 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.03.15 № 459
танай -ны № -т

ДОРНОД АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН
ТӨВИЙН ДАРГА Ц.МӨНХТӨР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймгийн Автотээврийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод аймгийн Автотээврийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Автотээврийн төв нь 14 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн үнэлгээний төлөвлөгөөг Автотээврийн үндэсний төвөөс 95.1 хувиар дүгнэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020473

ДОРНОД АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

ДОРНОД АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2022 оны 1 сарын 1	2022 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	81,399.79	2,201,425.01
1.1.06	Бараа материал	14,931,885.88	27,211,799.85
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	15,013,285.67	29,413,224.86
1.2.01	Үндсэн хөрөнгө	98,182,025.97	204,713,549.89
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	98,182,025.97	204,713,549.89
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	113,195,311.64	234,126,774.75
2.1.1.01	Дансны өглөг	0.00	6,764,145.95
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	9,840,600.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,840,600.00	6,764,145.95
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,840,600.00	6,764,145.95
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	17,824,453.50	17,824,453.50
2.3.09	Хуримтлагдсан ашиг	85,530,258.14	209,538,175.30
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	76,818,030.54
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	85,530,258.14	132,720,144.76
2.3.11	Эздийн өмчийн дүн	103,354,711.64	227,362,628.80
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	113,195,311.64	234,126,774.75

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	365,158,174.56	389,468,716.41
02	Борлуулалтын өртөг	363,093,131.47	369,884,543.98
03	Нийт ашиг(алдагдал)	2,065,043.09	19,584,172.43
05	Хүүний орлого	21,857.51	0.00
07	Зорчигч тээврийн орлого	28,342,580.00	84,451,316.01
08	Бусад орлого	0.00	493,149.99
08.1	Орлогын дүн	28,364,437.51	84,944,466.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	20,493,701.54	25,299,842.87
12	Бусад зардал	118,720.00	1,660,765.02
12.1	Зардлын дүн	20,612,421.54	26,960,607.89
17	Бусад ашиг (алдагдал)	-1,663,636.36	-750,000.00
17.1	Олз, гарзын дүн	-1,663,636.36	-750,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	8,153,422.70	76,818,030.54
20	Татварын дараах ашиг (алдагдал)	8,153,422.70	76,818,030.54
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	8,153,422.70	76,818,030.54

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	-552,125,164.70	672,373,941.29	120,248,776.59
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны з	0.00	552,125,164.70	-594,997,105.85	-42,871,941.15
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	8,153,422.70	8,153,422.70
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	17,824,453.50	0.00	0.00	17,824,453.50
09	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	17,824,453.50	0.00	85,530,258.14	103,354,711.64
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга	0.00	0.00	47,189,886.62	47,189,886.62
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	76,818,030.54	76,818,030.54
17	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	17,824,453.50	0.00	209,538,175.30	227,362,628.80

ДОРНОД АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,059,241,241.50	1,418,903,436.12
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	409,559,172.00	410,417,806.60
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	362,854,734.50	378,980,302.98
1.1.6	Бусад мөнгөн орлого	286,827,335.00	629,505,326.54
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,059,280,135.73	1,416,783,410.90
1.2.1	Ажиллагчдад төлсөн	208,632,386.65	222,983,267.24
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	28,524,777.58	29,432,585.05
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,377,120.00	1,319,414.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	63,305,659.33	63,791,251.34
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,406,000.00	15,304,495.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	211,331.00	146,056.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	745,822,861.17	1,083,806,342.27
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-38,894.23	2,120,025.22
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,857.51	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	21,857.51	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	21,857.51	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-17,036.72	2,120,025.22
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,436.51	81,399.79
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	81,399.79	2,201,425.01

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 475.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, албан шаардлага, 475.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн. Үүнд санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

Санхүүгийн тайланг төсвийн хуульд заасан цагалбарт хугацааг 13 хоногоор хоцроон 2023 оны 02 дугаар сарын 28-ний 32 дугаар албан бичгээр ирүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Зөвлөмж. Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Бараа материалын санхүүгийн тайланд тусгагдсан дүн тодруулга тайлангийн дүн хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын үлдэгдлийн баталгаажсан дүнг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

2. Өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаас 0.9 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, толилуулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийн тооцоо нийлсэн актаар баталгаажсан дүнг бүртгэл, санхүүгийн тайланд тусгах.

3. Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийн талаар.

Илрүүлэлт: АйсВн ХХК-тай байгуулсан зорчигч тээврийн үйлчилгээний хөлсийг тухай компаний менежерийн хувийн харилцах данс руу 473.4 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ДОРНОД АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Өгсөн зөвлөмж: Байгуулсан гэрээнд тусгагдсан харилцах дансанд үйлчилгээний хөлсийг шилжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-												
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Бараа материалын санхүүгийн тайланд тусгагдсан дүн тодруулга тайлангийн дүн хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	1	1,579.9	-	-	-	-	1	1,579.9	-	-	-	-
Санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаас зөрүүтэй тусгагдсан байна.	1	923.0	-	-	-	-	1	923.0	-	-	-	-
АйсВн ХХК-тай байгуулсан зорчигч тээврийн үйлчилгээний хөлсийг тухай компаний менежерийн хувийн харилцах данс руу шилжүүлсэн байна.	1	473,376.1	-	-	-	-	1	473,376.1	-	-	-	-
Санхүүгийн тайланг төсвийн хуульд заасан цагалбарт хугацааг хоцроон ирүүлсэн.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Дүн	4	475,879.0	-	-	1	-	3	475,879.0	-	-	-	-

ДОРНОД АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-